



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/376

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, "Ноордофф гавал тархины сан" хооронд 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 6 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЦОГЦЭЦЭГ

081209

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 29 өдрийн  
А/376 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харъяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Лэй Жу Пин Lai Jui Pin	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001829	Пластик мэс засал	Эмчлэх	2017-10-09 2017-10-15 7 хоног
2.	Чэн Зун Чунг Chen Zung Chung	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001830	Пластик мэс засал	Эмчлэх	2017-10-09 2017-10-15 7 хоног
3.	Ло Лун Жоу Lo Lun Jou	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001831	Пластик мэс засал	Эмчлэх	2017-10-09 2017-10-15 7 хоног

4.	Лу Чао Фен Luo Chiao Fen	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001832	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-10-09 2017-10-15 7 хоног
5.	Вуй Хуй Юу Wu Hui Yu	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГС0000224	Мэдээгүйжүүл гийн сувилахуй	Сувилах	2017-10-09 2017-10-15 7 хоног
6.	Ши Цу Вэй She Tzu Wei	Бүгд Найрамдах Хятад Ард Улс /Тайвань/	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГС0000225	Мэс заслын сувилахуй	Сувилах	2017-10-09 2017-10-15 7 хоног